



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2014 оны 12 сарын 04 өдөр

№ 2014/13

Улаанбаатар хот

Гишүүнээс хасах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 322, 323, 330, 331, 332, 333, 353, 354, 384 дугаар тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчтэй хувьцаат компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.17 дахь заалт, Гишүүнчлэлийн журмын 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.5.2, 8.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Грандлайн” ҮЦК, “Грийт секьюритис” ҮЦК, “Зууны гарц секьюритис” ҮЦК, “Мөнх-Огторгуй” ҮЦК, “Очир-Эрдэнэ инвест” ҮЦК, “Скайхан капитал” ҮЦК, “Соёмбо инвестмент” ҮЦК, “Туушин инвест” ҮЦК, “Юу би би ди” ҮЦК-иудыг гишүүнээс хассугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан гишүүнээс хасагдсан компаниудаас авах авлагыг барагдуулах ажлыг Захиргаа, санхүүгийн газар /Н.Дөл-Эрдэнэ/-т, гишүүнээс хасагдсан тухай мэдээллийг олон нийтэд мэдээлэхийг Зах зээлийн хөгжлийн газар /Ж.Мягмарсүрэн/-т тус тус даалгасугай.
3. Гишүүнээс хасагдсантай холбогдуулан мэдээллийн санд өөрчлөлт оруулах, “Үнэт цаасны төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-д мэдэгдэл хүргүүлэх, холбогдох баримт материалыг архивт хүлээлгэн өгөх, тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /үүрэг гүйцэтгэгч М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.
4. Цаашид гишүүний болон бүртгэлийн хураамжийн өр авлага үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Ангар/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б. НЯМАА